

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН 05 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ НАРЫН ХАМТАРСАН  
ТУШААЛ**

---

---

2020 оны 2. сарын 18 өдөр

Дугаар 956, A/20

Улаанбаатар хот

**Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Дотоодын цэргийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 136/-ын 136.5.2-ын "г" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Журам батлах тухай" Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагч нарын 2019 оны A/11, A/01 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын төв байранд хүн, ачаа, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх журам"-д дор дурдсан хэсгийг нэмсүгэй:

"4.10. Объектод гал түймэр болон гэнэтийн аюул, осол гарахаас урьдчилан сэргийлэх, шаардлага гарсан тохиолдолд харуулын цэгт байрлуулсан тусгай хайрцагт байлгах автомашины болон өрөөний нөөц түлхүүрийг захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн даргын зөвшөөрлөөр авч хэрэглүүлнэ.

4.11. Сэжигтэй байдал илэрвэл ангийн шуурхай удирдлагын жижүүрт болон объектын захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн даргад мэдэгдэж, зөвшөөрлийн дагуу харуулын цэгт байрлуулсан тусгай хайрцгаас түлхүүрийг авч хөндлөнгийн хүн байлцуулан, хэрэв ганцаар харуулын үүрэг гүйцэтгэж байгаа нөхцөлд энгэрийн камераар бичлэг хийж баталгаажуулан цоожийг онгойлгож өрөөнд нэвтэрнэ.

4.12. Энэ журмын 4.10, 4.11-д заасан нөхцөл байдал, авсан арга хэмжээний тухай "Хяналтын бүртгэл"-д тэмдэглэл хөтөлнө.

5.9. Объектод гал түймэр болон гэнэтийн аюул, осол гарахаас урьдчилан сэргийлэх, шаардлага гарсан тохиолдолд авч хэрэглэх зорилгоор автомашины болон өрөөний түлхүүрийн нэг хувийг тусгай хайрцагт хийж тус байгууллагын аюулгүй байдал хариуцсан ажилтны лацаар лацдан харуулд хүлээлгэн өгч, харуулын цэгт байрлуулна.

5.10. Харуулыг хооллох цагаар болон бие засах үед харуулын цэгт түр хугацаагаар байх албан хаагч /мэдээллийн төвийн мэргэжилтэнг/-ийн асуудлыг объектын захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн дарга томилж ажлуулна."

2. Мөн журмын 2.4-ийн "Ачаа, бараа, материалыг объектын захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн даргын зөвшөөрлөөр нэвтрүүлнэ." гэснийг "Ачаа, бараа, материалыг объектын захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн даргын зөвшөөрлөөр дотогш нэвтрүүлэх ба гадагш гаргана." гэж өөрчилсүгэй.

Тушаалыг холбогдох хүмүүст уншиж танилцуул.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
ДАРГА Д.МӨРӨН



ДОТООДЫН ЦЭРГИЙН 05 ДУГААР  
АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА  
ЦТАНСҮХ

1117152478  
2093451-CBT4967